


	Үндсэн тэжээлийн тоноглолын аюулгүй ашиглалтын заавар	ТТТ-ТА-02	БАТГАВ ГҮИЦЭГ ЭНД ХАХИРАЛ / М.Ганбаатар
		Хувилбар: 1	Баталсан огноо: 2020 он 04 сар 30 өдөр
		Тушаал №	А/58

## ҮНДСЭН ТЭЖЭЭЛИЙН ТОНОГЛОЛЫН АЮУЛГҮЙ АШИГЛАЛТЫН ЗААВАР

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:		М.Анхныбаяр	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:		Э.Амарсайхан	ХАБЭА-н ажилтан	

	Үндсэн тэжээлийн тоноглолын аюулгүй ашиглалтын заавар	ТТТ-ТА-02	БАТЛАВ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /...../ М.Ганбаатар
		Хувилбар: 1	Баталсан огноо: 2020 он ....сар .... өдөр
		Тушаал №	

# ҮНДСЭН ТЭЖЭЭЛИЙН ТОНОГЛОЛЫН АЮУЛГҮЙ АШИГЛАЛТЫН ЗААВАР

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:	/...../	М.Анхныбаяр	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:	/...../	Э.Амарсайхан	ХАБЭА-н ажилтан	

Үндсэн тэжээлийн тоноглолын аюулгүй ашиглалтын заавар	ТТТ-ТА-02
	Хувилбар: 1

БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ			
Хувилбар	Өөрчлөлтийн утга	Боловсруулсан	Тушаалын дугаар/Огноо
1			

Үндсэн тэжээлийн тоноглолын аюулгүй ашиглалтын заавар	ТТТ-ТА-02
	Хувилбар: 1

## Агуулга

Нэг. ЗОРИЛГО .....	4
Хоёр. ХАМРАХ ХҮРЭЭ .....	4
Гурав. ХАМААРАХ ТАЛУУД .....	4
Дөрөв. БАРИМТ БИЧГИЙН НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ, ТОВЧИЛСОН ҮГ ...	4
Тав. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА .....	5
Зургаа. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА .....	5
Долоо. ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛ .....	12
Найм. АШИГЛАЛТЫН ЗААВАР .....	12
Ес. ЧАНАРЫН ШААРДЛАГА .....	15
Арав. БҮРТГЭЛ .....	15
Арван нэг. ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧИГ .....	15
Арван хоёр. ХАВСРАЛТУУД .....	15

Үндсэн тэжээлийн тоноглолын аюулгүй ашиглалтын заавар	ТТТ-ТА-02
	Хувилбар: 1

### НЭГ. ЗОРИЛГО

- 1.1. Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлийн тоноглол болох үндсэн тэжээлийн нөөцийн бункер, барьцалдуулагчийн бункер, цнейк төхөөрөмжүүдийг аюул, эрсдэлгүй, эвдрэл гэмтэлгүй зөв ашиглаж, ажиллуулахад оршино.

### ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1. Үйлдвэрийн бүсэд байрлах үндсэн тэжээлийн төхөөрөмжийг ашиглаж ажиллуулах хүрээнд үйлчилнэ.

### ГУРАВ. ХАМААРАХ ТАЛУУД

Хүснэгт 1

д/д	Нэгж	Албан тушаал
1	Ашиглалтын хэсэг	Ашиглалтын инженер
2		Ашиглалтын мастер-ээлжийн дарга
3		Ээлжийн дарга нар-шугмын ахлах
4		Үндсэн тэжээлийн машинч
5	Засварын хэсэг	Засварын инженер-мастер
6		Тоноглолын засварчид
8	Цахилгааны хэсэг	Цахилгааны инженер
9		Ээлжийн монтерууд

### ДӨРӨВ. БАРИМТ БИЧГИЙН НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ, ТОВЧИЛСОН ҮГ

- 4.1 Нэр томъёоны тодорхойлолт

Хүснэгт 2

д/д	Нэр томъёо	Тодорхойлолт
1		

- 4.2 Товчилсон үг

Хүснэгт 3

д/д	Товчилсон үг	Тайлбар
1		
2		
3		

Үндсэн тэжээлийн тоноглолын аюулгүй ашиглалтын заавар	ТТТ-ТА-02
	Хувилбар: 1

### ТАВ. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

д/д	Албан тушаал	Үүрэг хариуцлага
1	Үйлдвэрийн дарга	Тоноглолын горим ажиллагааг тодорхойлох.
		Тоноглолын талаарх мэдээллийг хүлээн авч гарсан гэмтлийг устгах арга хэмжээг зохион байгуулах.
		Техник ашиглалтын зааврыг дагаж мөрдүүлэх.
2	Ашиглалтын инженер	Тоноглолын горим ажиллагааг тодорхойлох.
		Тоноглолын талаарх мэдээллийг хүлээн авч гарсан гэмтлийг устгах арга хэмжээг зохион байгуулах.
		Техник ашиглалтын зааврыг шинэчлэн боловсруулж батлуулах.
3	Засварын мастер	Техник ашиглалтын зааврыг дагаж мөрдүүлэх.
		Засвар, техник үйлчилгээг хариуцна.
		Тоноглолын талаарх мэдээллийг хүлээн авч гарсан гэмтлийг устгах.
4	Тоноглолын засварын бригад	Графикийн дагуу тоноглолд үзлэг үйлчилгээ хийх.
		Тоноглолын талаарх мэдээллийг хүлээн авч гарсан гэмтлийг устгах.
5	Ээлжийн дарга нар	Горим ажиллагааны дагуу ажиллуулах.
		Засварын ажлын байрыг зөв бэлтгэх, хүлээж авах.
		Тоноглолын талаарх мэдээллийг хүлээн авч гарсан гэмтлийг устгах арга хэмжээг зохион байгуулах.
		Тоноглолын төлөв байдлын талаар мэдээлэл дамжуулах.
6	Бутлагчийн машинч	Техник ашиглалтын зааврыг дагаж мөрдүүлэх.
		Горим ажиллагааны дагуу эвдрэл гэмтэлгүй зөв ашиглах.
		Тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ үйлчилгээг хийх.
		Засварын ажлын байрыг зөв бэлтгэх, хүлээж авах.
7	Цахилгааны инженер	Тоноглолын төлөв байдлын талаар мэдээлэл дамжуулах.
		Тоноглолын цахилгаан хөдөлгүүр болон шугам, кабель, гэрэлтүүлгийн найдвартай ажиллагааг хангах
		Тоноглолын цахилгаан хөдөлгүүр болон шугам, кабель, гэрэлтүүлгийн үзлэг үйлчилгээг тогтмол хийх.
8	Ээлжийн монтерууд	Цахилгаан тоноглолын гэмтлийн талаар мэдээлэл авах.
		Цахилгаан тоноглолын схем цуглуулах, задлах

### ЗУРГАА. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

#### 6.1. Ажиллагааны үеийн шаардлага

1. Үндсэн тэжээлийн тоноглолтой ажиллах хүмүүс ажлын хувцас бүрэн зөв өмсөнө.
2. Өмдний түрийг гутлын дотуур хийж, ханцуй ба хормойг унжихааргүй уяж бэхэлсэн байна. Урт үстэй хүн малгай дотуур үсийг шууж хийнэ.
3. Наряд, ам шийдвэр системийг дагаж мөрдөх.
4. Өндөрт ажиллах хүмүүс ажлын тавцан руу гарах шатаар 3 цэгийн дүрэм /шатруу харсан байрлалаар гар, хөл болох мөчдүүдээс 3 нь ямагт хөдөлгөөнгүй байрлалд гулгах, халитрахаас сэргийлэх/ баримтлан өгсөж уруудна.

Үндсэн тэжээлийн тоноглолын аюулгүй ашиглалтын заавар	ТТТ-ТА-02
	Хувилбар: 1

5. Ажлын шат, тавцан байхгүй эсвэл хаалт хашилтгүй ажлын тавцан дээр ажиллах хүмүүс өндрөөс унахаас хамгаалах хэрэгсэл бүс, амь олс зэргийг заавал хэрэглэнэ.
6. Ажиллаж байгаа механизмд үзлэг хийхдээ хаалт хамгаалалтыг нягтлан шалгаж гарын араар дарах буюу тусгай саваагаар чагнаж үзнэ.
7. Бүтээгдэхүүний терминалууд болон газардуулах шаардлагатай металл хэсгүүдийг сайн газардуулсан байх ёстой.
8. Эргэх механизмыг явуулах, мөн туршихын өмнө муфьтэн холбоосыг холбож, хөдлөх бүх хэсгийн хамгаалалт хашилтыг тавьж аюулгүйн тэмдэгийг авч багаж хэрэгслийг зайлуулах ба ажлын байрнаас тухайн ажилд холбогдолгүй гадны хүмүүсийг гаргасан байна.
9. Үндсэн тэжээлийн тоног төхөөрөмжийг засварт оруулахдаа механизм нь зогсоогдсон, түүний хаах арматурууд нь /таг, хаалт, шибер хавхлагууд ба бусад/ ажил гүйцэтгэх аюулгүй байдлыг хангах байдалд байрласан байх ёстой.
10. Хүчдэлээс таслагдсан хөдөлгүүр, механизмын арматуруудыг гинж ба бусад хэрэгслийн тусламжтайгаар цоожлон хааж, буруу үйлдлээр залгагдах боломжгүй болгосон байвал зохино.
11. Туслах дамжуулах ба механизмын явуулах байгууламж дээр хориглох плактууд өлгөж ажил гүйцэтгэх байранд “Энд хүмүүс ажиллаж байна “ гэсэн плакат тавьсан байх ёстой .
12. Цахилгаан дамжуулагатай эргэх механизмуудыг засварт оруулахдаа цахилгааны мэргэжлийн ажилтнаар цахилгаан схемийг салгуулна.

**6.2. Өргөх төхөөрөмж ашиглан гүйцэтгэх ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа**

1. Ган татлагатай өргөгч механизм болон гар тайл эсвэл ороогч зэрэг ачаа татагч төхөөрөмж ашиглах ажилтан нь тусгай хөтөлбөрөөр суралцаж, байгууллагын аттестатчлалын комиссоос ачаа өргөх механизм болон тоног төхөөрөмж ашиглах эрх авсан байна.
2. Гар тайл, гар ороогчийг удирдах, эдгээрт ачааг тогтоох хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг шууд удирдлагаас (ээлжийн ахлах, ажил удирдагч) 12 сард нэгээс доошгүй удаа авсан байна.
3. Өргөгч төхөөрөмжтэй ажиллах ажилтан дараах зүйлсийг мэддэг, эзэмшсэн байх шаардлагатай:
  - Ачаа өргөх төхөөрөмжийн зориулалт, хүчин чадал, техникийн тодорхойлолт;
  - Техник үйлчилгээ, засвар, үзлэгийн хуваарь, өмнөх техник үйлчилгээ, засвар, үзлэгийн үр дүн;

Үндсэн тэжээлийн тоноглолын аюулгүй ашиглалтын заавар	ТТТ-ТА-02
	Хувилбар: 1

- Ачааг оосорлох, өлгөх аюулгүй арга барил;
  - Ачааг зөөх хураах дараалал;
  - Ган татлагатай, гинж, хөдөлгөөнт тохируулагч болон баглаа боодолд тавигдах шаардлага, тэдгээрийн элэгдлийн норм;
  - Өргөх төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хариуцсан инженер-техникийн ажилтан (ашиглалтын инженер, ээлжийн ахлах), засварчинтай яаралтай холбогдох арга;
  - Гал унтраах багаж зэвсэглэлийн байршил, түүнийг ашиглах арга аргачлал;
4. Үйлдвэрийн байранд ачааг оосорлох, өлгөх аргачлал, зөөх ачааны зөвшөөрөгдөх жин, ачааг хураах схемийг хананд байрлуулсан байна.
  5. Өргөх төхөөрөмжийн хуваарийн дагуу техникийн засвар, үйлчилгээ, үзлэгийг хийсэн байна.
  6. Өргөх төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг хэвийн ажилгаа хариуцсан инженер-техникийн ажилтан, түүнийг ажиллуулдаг ажилтан хоёр бүрэн хариуцна.
  7. Ажлын байранд дараах зүйлсэд үзлэг хийнэ:
    - Өргөх тоног төхөөрөмжид гадна үзлэг хийж, түүний хэвийн ажиллагаа, тоног төхөөрөмжийн дугаар, хуваарьт туршилт тохируулга, засвар үйлчилгээ, үзлэг хийгдэж ашиглалтын паспортод бүртгэл хөтлөлт хийгдсэн эсэх;
    - Өргөх ачааны баглаа боодол бүрэн бүтэн эсэх, түүн дээрх дугаар, зориулалт, жин бүхий бичиг байгаа эсэх;
    - Дамжуулагч, холхивч, ган татлагын канатын тосолгоо, сальник, тосолгооны төхөөрөмжийн байдал;
    - Төхөөрөмжийн метал эд ангийн гагнасан, боосон зэрэг бэхэлсэн хэсгүүд;
    - Ган татлага, гинж, тэдгээрийн дамарт бэхлэгдсэн байдал;
    - Дэгээ, түүний бэхэлгээ, ээлжийн ачаа базагч;
  8. Үзлэгийн дараа ачаа өргөх аюултай орчинд хүн байгаа эсэхийг нягталж, тус бүсэд шаардлагагүй хүмүүсийг нэвтрүүлэхгүй байх боломжийг бүрдүүлнэ.
  9. Ажлыг гүйцэтгэхээс өмнө төхөөрөмжийг асааж буюу хоосон явуулж хэвийн ажиллагааг шалгана.
  10. Үзлэг болон шалгалтаар ямар нэг доголдол ажиглагдвал, түүнийг засах арга хэмжээ авна. Хэрэв өөрөө хийх боломжгүй бол ажлаа эхлүүлэхгүйгээр шууд удирдлагад мэдэгдэнэ.
  11. Ажил эхлүүлэхгүй байх тохиолдлууд:
    - Гадна их биед цууралт, гажилт үүссэн, эрэг боолт эсвэл бэхэлгээ суларсан;
    - Канатын бэхэлгээний хавчигч гэмтсэн эсвэл байхгүй болсон, боолт суларсан;



Үндсэн тэжээлийн тоноглолын аюулгүй ашиглалтын заавар	ТТТ-ТА-02
	Хувилбар: 1

- Ачилтын канат эмтэрсэн, элэгдэл нормыг давсан, түгжээ нь мултарсан болон дэгээний нугалаа гэмтэлтэй;
  - Ачаа өргөх төхөөрөмж болон түүний эд анги гэмтэлтэй.
  - Ган татлага блок гэмтсэн;
  - Дэгээ болон блок эргэлдэхгүй болсон;
  - Өргөх төхөөрөмжийн урьдчилан сэргийлэх үзлэгийн эсвэл ашиглалтын болон техникийн үйлчилгээний хугацаа дууссан;
  - Ажлын байрны гэрэлтүүлэг хангалтгүй;
12. Өргөх төхөөрөмжийг ажиллуулж цэвэрлэх, тослох, засварлахыг хориглоно.
13. Ажлын байранд зөвшөөрөлгүй хүн оруулах, төхөөрөмжийн удирдлагыг шууд удирдлагын шийдвэргүйгээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
14. Ачаа өргөхөд заавал ханцуйвч хэрэглэнэ.
15. Өргөх төхөөрөмжтэй дараах зарчмыг баримтлана:
- Хэн өгснөөс үл хамааран “Зогс” дохиог биелүүлнэ;
  - Өргөх төхөөрөмжийн бүсэд гадны хүн байхгүй үед ачааг өргөнө;
  - Өргөсөн ачааны доогуур болон барилга байгууламжийн хана, машин механизм, тоног төхөөрөмж зэрэг хатуу биет ачаа хоёрын хооронд хүн зорчихгүй, орж зогсохгүй байхаар ажлыг төлөвлөнө.
  - Ган татлага налуу байрлалд орохоос сэргийлж, дэгээг ачааны дээр байрлуулна;
  - Ачааг 20-30 см өндөрт өргөж, оосорлолт зөв, бэхэлгээ найдвартай эсэхийг нягталсны дараа шаардлагатай өндөрт өргөнө;
  - Ачааг хэвтээ чиглэлд шилжүүлэн зөөх замд тохиолдож болох зүйлээс 50 см өндөрт өргөсөн байна;
  - Цөөн ширхэгтэй, нунтаг, шингэн, хүндийн төвийг тодорхойлох боломжгүй ачааг сав боодолд хийж өргөнө;
  - Ажиллаагүй байгаа өргөгч төхөөрөмжийн дэгээг ямагт дээд байрлалд өргөсөн байна;
  - Ачааг оосорлохдоо батлагдсан оосорлолтын схемийн дагуу хийнэ. Оосорлолтын схемийг боловсруулаагүй ачааг зөөхдөө аюулгүй ажиллагааг хариуцсан удирдах ажилтныг байлцуулна;
  - Ачааг технологийн картан дагуу унах, асгарах, гулгах эрсдлийг арилгаж, тогтоосон газар жигд буулгана;
  - Ачааг жигд аажим өргөнө;
  - Оосорлогчийн үнэмлэхгүй ажилтан ажиллуулахгүй;

Үндсэн тэжээлийн тоноглолын аюулгүй ашиглалтын заавар	ТТТ-ТА-02
	Хувилбар: 1

- Өргөх төхөөрөмжийн даацаас хэтэрсэн ачаа, жинг тодорхойлох боломжгүй, асгарсан, газарт бэхлэгдсэн ачааг өргөхийг хориглоно;
- Ачааг огцом өргөхийг хориглоно;
- Ачааг өргөсөн байдалд орхихыг хориглоно;
- Газар шүргэсэн, бусад ачаатай холилдсон, боолтоор тээглүүлсэн, эд зүйлд орооцолдсон ачааг өргөж тасдах, урах үйлдэл хийхийг хориглоно;
- Хүнтэй ачаа, хүн гараараа түшиж тэнцвэрийг олж байгаа ачааг өргөхийг хориглоно;
- Тусгай саванд хийгээгүй шахсан, шингэрүүлсэн хийн баллоныг өргөхийг хориглоно;
- 16. Дараах тохиолдолд ажлыг зогсоож шууд удирдлагад мэдэгдэнэ.
- Өргөх төхөөрөмжийн механизм, төмөр хийц эвдрэх;
- Ажлын байрны гэрэлтүүлэг хангалтгүй;
- Хүчтэй цасан болон шороон шуурга, адаар бороо, манан буусан;
- Агаарын температур төхөөрөмжийн паспорт дээр заасан хэмжээнээс бага болсон;
- Барабан болон блокоос ган татлага буруу хураасан, ган татлага гэмтсэн;
- Төхөөрөмжийг ажлын байранд найдваргүй бэхэлсэн;
- Цахилгаан дамжуулагчийн хаалт хамгаалалт байхгүй;

16. Ажил дууссаны дараа төхөөрөмжийг тогтоосон зогсоолд тавьж, дэгээг дээш өргөн хамгийн дээд цэгт байрлуулна.

### **6.3. Хориглох зүйл**

1. Хэвлэгч төхөөрөмжийг ажиллаж байх үед түүний тагийг онгойлохыг
2. Хэвлэгч төхөөрөмжийн цахилгаан схемийг цахилгааны мэргэжлийн бус ажилтан дур мэдэн салгах ба залгахыг
3. Хэвлэгч төхөөрөмж ажиллаж байх үед ажлын байрыг дур мэдэн орхихыг
4. Өндөрт ажиллах хүмүүс ажлын тавцан руу гарах шатаар шатруу нуруугаар харуулж өгсөж уруудах үйлдэл хийхийг
5. Өндөрт байрлах ажлын тавцангаас биеийн аль нэг хэсгийг гадуур байлгахыг
6. Ажиллаж байгаа эргэх механизмыг гараар зогсоох, түүний хөдөлгөөнтэй байгаа хэсэгт биеэр хүрэхийг
7. Ажиллаж байгаа эргэх механизмын дээгүүр доогуур арчих, цэвэрлэгээ хийх, цаагуур нь гараа оруулж тослох, тэрчлэн хашилт /муфьтны хамгаалалт/ дээр гарч зогсох ба давж гарах, хэт ойртох, өнгийх, ямар нэг эд зүйлийг шургуулах, унагах, мөн дээр нь аливаа зүйлийг тавьж орхихыг
8. Эргэх механизмыг ажиллаж байхад нь түүний эргэх хэсгийн хаалт, хамгаалалтыг авахыг

Үндсэн тэжээлийн тоноглолын аюулгүй ашиглалтын заавар	ТТТ-ТА-02
	Хувилбар: 1

9. Үндсэн тэжээлийн тоног төхөөрөмжийн хаалт хамгаалалт нь ан цав үүссэн буюу огт байхгүй, голын чигжээсгүй /сальник/, цахилгаан хөдөлгүүр халалттай, доргио чичиргээ ихтэй ба бүрэн бус байвал түүнийг турших болон ажиллуулахыг тус тус хориглоно.
10. Засвар үйлчилгээний ажил явагдаж байхад үндсэн засварын бригадаас бусад хүнийг ажлын бүсэд оруулах, танилцуулах, хүргэх үйлдлүүд хамаарна.
11. Үйлдвэрлэлийн шугаман процесс явагдаж байх үед аваарын зогсолтоос бусад үед эргэлдэх механизмтай ажиллах, түүнд гацсан, доголдол үүссэн тоноглолд дур мэдэж хүрэх, ойртох үйлдлүүд хамаарна.

#### **6.4. Үйлдвэрлэлийн осол, осолд дөхсөн тохиолдол гарсан үед авах арга хэмжээ**

1. Та (хамгийн ойрын гэрч) осолдогчид анхны тусламж үзүүлэх үүрэгтэй ба аюултай тохиолдол, гэмтэл бүрийг тухайн үйлдвэр, хэсгийн дарга, мастер, инженер буюу уг ажлыг хариуцагч зохих удирдагчид мэдэгдэнэ.
2. Ажил олгогч (хамгийн ойрын гэрч) нь осол, аюултай тохиолдол гарсан газрыг комисс судлахаар иртэл өөрчлөлгүй, хэвээр хадгалах ёстой.
3. Ажил олгогч нь осолдогчийг эмнэлэгт хүргэж өгөх үүрэгтэй.

#### **6.5. Тоног төхөөрөмж дээр тавигдах хамгаалах хэрэгсэл, таних тэмдэг**



1. Үндсэн ажиллагааны тоног төхөөрөмж, түүний туслах тоноглолууд нь ямар нэгэн эргэх, давших, ганхах (савлах) хөдөлгөөнөөр ажилладаг бол тухайн ажлын механизмууд нь (араат механизм, оосрон дамжуулга, хөдөлгүүр, мүфт, гинж, туузан дамжуулга зэргүүд) заавал хатуу хаалттай байна.
2. Тухайн тоноглолд байгаа эргэх, давших, ганхах хөдөлгөөн хийж байгаа механизмуудын хаалтууд дээр таних тэмдэг байршуулсан байх (гэрэл ойлгогч, хурц тод өнгө – улаан, шар, хашлага, анхааруулах тэмдэг, самбар, дуут дохионууд гэх мэт) ёстой.
3. Хөдөлгөөнт механизмтай ажлын орчин нь гэрэлтүүлэг сайтай, агаар сэлгэлт хэвийн, ажлын болон ажлын бус орчины таних тэмдэг, шугамыг заасан байна.

Үндсэн тэжээлийн тоноглолын аюулгүй ашиглалтын заавар	ТТТ-ТА-02
	Хувилбар: 1

4. Тоног төхөөрөмж тус бүр дээр ажиллах ажилчинд зориулсан заавар, зөвлөмжүүдийг машин тоноглол дээр наах, байршуулах (ХАБ-ын заавар, цахилгааны болон эргэх хөдөлгөөний тэмдэг, чиглэл гэх мэт).

#### **6.6. Ажилтанд тавигдах шаардлага**

1. Хөдөлмөр хамгаалах нэг бүрийн хэрэгслийг (ажлын тусгай хувцас, гутал, нэг бүрийн болон нийтийн хамгаалах хэрэгсэл) Компанийн дотоод стандартын дагуу гүйцэтгэж буй ажлын онцлогт тохируулан хэрэглэнэ.
2. Хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэж, бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллана.
3. Компаниас олгосон ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг үйлдвэрийн бүсэд зөвхөн ажлын байран дээр ажил гүйцэтгэх үедээ бүрэн зөв зориулалтын дагуу хэрэглэнэ. Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг үйлдвэрийн бүсээс өөр газарт өмсөж хэрэглэхийг хориглоно.
4. Гадны гэрээт байгууллагын ажилтнууд нь ажлын тусгай хувцас, гутал, дуулга малгай, хамгаалалтын нүдний шил болон тухайн үйлдвэр, хэсэг нэгжид заавал хэрэглэх шаардлагатай бусад хувийн хамгаалах хэрэгслийг бүрэн хэрэглэнэ.

#### **6.7. Хувийн хамгаалах хэрэгсэл**

##### **❖ Нүдний хамгаалалт:**

- Хамгаалалтын нүдний шилийг засварын газар, зохих тэмдэг тавьсан үйлдвэрлэлийн ажлын байрууд, лабораторид болон онцгой шаардлагатай ажлын байруудад хэрэглэнэ.

##### **❖ Толгойн хамгаалалт:**

- Хамгаалалтын дуулгыг зохих тэмдэг тавьсан, шаардлагатай газруудад болон үйлдвэрийн бүсэд заавал өмсөнө.

- Дуулга малгайг толгойноос унагахгүйн тулд зориулалтын бүчийг эрүүн доогуур бүчилнэ.

##### **❖ Хөлийн хамгаалалт:**

- Ажлын байрны нөхцөлд тохирсон хамгаалалтын гутлыг хэрэглэнэ.

- Чийг, устай газар резинэн гутал өмсөнө.

##### **❖ Гарын хамгаалалт:**

- Гар гэмтэх эрсдэлтэй ажил гүйцэтгэхдээ бээлий өмсөх шаардлагатай. Тусгай ажил гүйцэтгэх ажилтнууд гарын тусгай хамгаалах бээлий хэрэглэнэ.

##### **❖ Сонсголын эрхтний хамгаалалт:**

- Шуугиан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн ажлын байруудад сонсголын эрхтний хамгаалах хэрэгслийг хэрэглэнэ.

##### **❖ Амьсгалын эрхтний хамгаалалт:**

Үндсэн тэжээлийн тоноглолын аюулгүй ашиглалтын заавар	ТТТ-ТА-02
	Хувилбар: 1

- Зөвшөөрөгдсөн дээд хэмжээнээс хэтэрсэн хий, утаа, уур, тоостой орчинд амьсгалын эрхтний хамгаалалт хэрэглэнэ.
- Амьсгалын эрхтнийг хамгаалах хэрэгслийн зориулалт, хязгаарлалтыг мэддэг байх хэрэгтэй. Амьсгалын эрхтэний хамгаалах хэрэгслийг зааврын дагуу хэрэглэж, үйлчилгээ хийх ёстой.
- Хорт утааны баг болон амьсгалын эрхтнийг хамгаалах бусад хэрэгслүүдийг хэрэглэх ажилтнууд тусгай сургалтанд хамрагдаж, эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн байна.

❖ **Өндрөөс унахаас хамгаалах:**

- Өндөрт гүйцэтгэх ажилд хаалт, хашилтгүй өндөрлөг газраас 2 метрээс багагүй зайнд байрлах, 1.3 м-ээс дээш өндөрт гүйцэтгэх ажил хамаарна. Энэ ажлыг гүйцэтгэх үед хаалт хашилтын тоноглолуудыг хэрэглэх боломжгүй тохиолдолд хамгаалалтын олон талд уяатай бүс, татлага хэрэглэнэ.

### **ДОЛОО. ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛ**

- 7.1. Дуу чимээтэй.
- 7.2. Доргио, чичиргээтэй.
- 7.3. Тоос ихтэй.
- 7.4. Тэсэрч дэлбэрэх.
- 7.5. Эргэх механизмтай.
- 7.6. Өндөрт.
- 7.7. Дуу чимээтэй.
- 7.8. Цахилгаан хүчдэлтэй.
- 7.9. Хөдөлгөөнт техник (Сэрээт өргөгч)-ийн ажлын талбарт

### **НАЙМ. АШИГЛАЛТЫН ЗААВАР**

8.1. Тэжээлийн бункер

Үйлдвэрийн технологийн шугамд 0.5-тай мидлинг нөөцөлж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн хангахад бункерийн үүрэг оршино.

❖ **Бункерийн техникийн бүтэц зохион байгуулалт, ажиллах зарчим**

Үндсэн тэжээлийн бункер доорх эд ангиудаас бүрдэнэ.

1. Их бие
2. Тулгуур бэхэлгээ, бүслүүр
3. Доргиур
4. Шибер
5. Ажлын тавцан, шат

Үндсэн тэжээлийн тоноглолын аюулгүй ашиглалтын заавар	ТТТ-ТА-02
	Хувилбар: 1

6. Люк

7. Гэрэлтүүлэг зэргээс бүрдэнэ.

Бутлуураас конвейероор тээвэрлэгдэж ирсэн мидлинг үндсэн тэжээлийн бункерт орж нөөцлөгдөнө. Доргиурын ажиллагаар нь үндсэн тэжээлийг нэгэн жигд буулгах мөн хананд тогтоц үүсэхээс урьдчилан сэргийлнэ. Шибер нь шнейк рүү буух үндсэн тэжээлийн хэмжээг тохируулна.

8.2. Шнек

Үндсэн тэжээлийг холигч тоног төхөөрөмж рүү тасралтгүй, жигд тээвэрлэж хангах үүрэгтэй.

❖ **Бүтэц зохион байгуулалт, ажиллах зарчим**

1. Удирлагын самбар
2. Цахилгаан хөдөлгүүр
3. Инвертер
4. Редуктор
5. Их бие
6. Шурган дамжуулагч
7. Тулгуур хөл, бэхэлгээ

8.3. Цавууны бункер

Хуурай барьцалдуулагчийг нөөцөлж хуурай барьцалдуулагчийн шнейк рүү унагах үүрэгтэй.

❖ **Бүтэц, зохион байгуулалт:**

1. Их бие
2. Ажлын тавцан, шат
3. Тулгуур хөл
4. Тайл
5. Зам, рам

8.4. Хуурай барьцалдуулагчийн шнейк

Хуурай барьцалдуулагчийг нэгэн жигд үндсэн тэжээлийн шнейк рүү тээвэрлэх зорилготой.

❖ **Бүтэц зохион байгуулалт**

1. Удирдлагын самбар
2. Цахилгаан хөдөлгүүр
3. Инвертер
4. Редуктор
5. Их бие

Үндсэн тэжээлийн тоноглолын аюулгүй ашиглалтын заавар	ТТТ-ТА-02
	Хувилбар: 1

6. Шурган дамжуулагч

7. Тулгуур хөл, бэхэлгээ

8.5. Хуурай барьцалдуулагчийн шнейк ажилд залгах.

Зөвхөн ээлжийн дарга болон ээлжийн ахлахын шийдвэрээр операторт мэдэгдэн удирдах шитнээс залгагдана. Хамгийн түрүүнд савалгааруу орох конвейр хатаагчийн доод богино конвейр болон хатаагчаас гарсан конвейруудыг залгана, үүний дараа гинжнүүдийг дарааллын дагуу доороос нь шалгаж ажиллуулж шугам залга

гдахад бэлэн болгоно. Шахмал түлшний тэжээлийг өгөхийн өмнө зуухыг галлаж тодорхой чанарын шаардлага хүрэхүйц түлш гарах хэмжээнд хатаагчийн температурыг өсгөсний дараа шугам бүрэн залгагдахад бэлэн болно. Дараа нь хатаагчруу орох конвейр холигчруу буцах конвейр хэвлэгчийн богино конвейер хэвлэгч хэвлэгчрүү орох конвейр холигч-1 холигч-2 шнек.

8.6. Хуурай барьцалдуулагчийн шнейк зогсоох.

Мөн ээлжийн дарга болон ээлжийн ахлахын шийдвэрээр шугамыг зогсооно. Шнейк зогссон тохиолдолд холигчийг хоосолж дамжлагуудыг нэг нэгээр зогсооно. Гинжит хатаагчны гинж түлштэй явж байгаа тохиолдолд хатаагчаас гарсан конвейрыг зогсоохыг хориглоно. Тэжээлийн бункер дүүрч дууссан тохиолдолд тэжээлийн конвейерыг зогсооно.

8.7. Тоноглолын техник үйлчилгээ.

*Хүснэгт. Тосолгоо хийгдэх хугацаа*

Эд анги	Тосолгоо
Шнекийн холхивчууд	-40°C, +135 °C хүртэлх температурт тэсвэртэй Зуурамтгай чанар 30v
Холхивч	-40°C, +135 °C хүртэлх температурт тэсвэртэй Зуурамтгай чанар 30v

8.8. Тоноглолыг засварт гаргах, хүлээн авах

❖ Шнек тоноглолыг засварт гаргахдаа доорх арга хэмжээнүүдийг авна. Үүнд:

1. Дамжлагыг зогсоож цахилгаан схем задалж цоож зүүх.
2. Дамжлагын рам, лоток, буух хоолой гэх мэт гал цогшилт үүсэж болзошгүй газруудыг сайтар цэвэрлэх.
3. Галын анхан шатны багаж хэрэгслийг бэлдэх.

❖ Туузан дамжуулагчийг засвараас хүлээж авах

1. Засвар орсон ажлын байрыг бригадын бүрэлдэхүүнээр бүрэн цэвэрлүүлж хүлээж авах.
2. Засвар орсон газруудыг сайтар цэвэрлэх.
3. Цахилгаан схем цуглуулах.
4. Дамжлагыг залгаж засварын ажлыг шалгах.

Үндсэн тэжээлийн тоноглолын аюулгүй ашиглалтын заавар	ТТТ-ТА-02
	Хувилбар: 1

### ЕС. ЧАНАРЫН ШААРДЛАГА

- 9.1. Үндсэн тэжээлээс гарч байгаа нүүрсний хэмжээ 0,5-0,7мм-с ихгүй байх.
- 9.2. Цавууны шнейкээс ирж байгаа хуурай барьцалдуулагч тасалдахгүй нэгэн жигд ирж байгаа эсэх
- 9.3. Холхивчнуудын халалт 60С-ээс ихгүй байх.
- 9.4. Их бие, ротор, холхивчууд доргиогүй байх.
- 9.5. Таг болон, засварын хаалгануудын нягтруулга бүрэн бүтэн тоосролтгүй байх.

### АРАВ. БҮРТГЭЛ

Хүснэгт 4

д/д	Бүртгэлийн нэр	Бүртгэлийн дугаар
1	Удирдах щитний операторын шуурхай ажиллагааны журнал	
2	Ажилласан цагийн бүртгэл	
3	Гэмтлийн журнал	
4	Оношлогооны акт	

### АРВАН НЭГ. ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧИГ

Хүснэгт 5

д/д	Баримт бичгийн нэр	Баримт бичгийн дугаар
1	Урьдчилан сэргийлэх үзлэг үйлчилгээний график	График нь жил бүр өөрчлөгдөн батлагдана.
2	Дохиолол хамгаалалт блокировка шалгах график	График нь жил бүр өөрчлөгдөн батлагдана.
3	Тоноглолын техник үйлчилгээ хийх график	График нь жил бүр өөрчлөгдөн батлагдана.

### АРВАН ХОЁР. ХАВСРАЛТУУД